

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны ... дугаар
сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

**Үйлчилгээ үзүүлэх аргачлал, заавар, шалгуур, журам,
гэрээний загвар батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх аргачлал, заавар, үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг нэгдүгээр, "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газар /Д.Ренчиндорж/, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /З.Энхболд/- т тус тус даалгасугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А/91, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны А/63, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/09, 2019 оны А/65, 2019 оны А/374, 2023 оны А/180 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны дүгээр сарын-ны өдрийн..... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АРГАЧЛАЛ, ЗААВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТ ТАВИГДАХ ШАЛГУУР, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан өрх, иргэнд тус хуулийн 18.1-т заасан үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын оролцоотойгоор үзүүлэхэд энэхүү журмыг баримтална.

1.2.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Нийгмийн халамжийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үзүүлнэ.

1.3.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум хорооны нийгмийн ажилтан нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг төлөвлөн, үзүүлэхдээ тухайн орон нутгийн иргэд, олон нийтийн санал, орон нутгийн өмнө тулгамдаж буй асуудал, хэрэгцээ, шаардлагад үндэслэн үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлэх төлөвлөгөө, орон нутгийн нөөцийг тодорхойлон төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж зэрэг оролцогч талуудыг татан оролцуулж, хамтран ажиллана.

Хоёр. Үйлчилгээнд баримтлах зарчим

2.1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

- 2.1.1.хүний эрхийг дээдлэх, хувь хүний нэр төрд хүндэтгэлтэй хандах;
- 2.1.2.үйлчлүүлэгч төвтэй, тэдний хувийн онцлог хэрэгцээ, сэтгэл зүй, шашин шүтлэг, зан заншлыг хүндэтгэх;
- 2.1.3 гэр бүл, орон нутаг, олон нийтийн оролцоог дэмжих;
- 2.1.4.үл ялгаварлах, хараат бус байдлыг хүндэтгэх;
- 2.1.5.үйлчилгээ үзүүлж буй иргэдийн нууцыг хадгалах;
- 2.1.6.хүчирхийлэл, аливаа төрлийн дарамт, мөлжлөгөөс сэргийлэх, хамгаалах;
- 2.1.7.үйлчилгээ нь мэргэжлийн, чанартай, ил тод, хүртээмжтэй байх.

Гурав. Үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргах

3.1.Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасан өрх, иргэн /цаашид “өрх, иргэн” гэх/ энэ журмын 4 дүгээр зүйлд заасан багц үйлчилгээний төрлөөс сонгож, үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ нийгмийн халамжийн нэгдсэн систем ehalamj.mn /цаашид “систем” гэх/-д цахимаар гаргана.

3.2. Үйлчилгээнд хамрагдах “өрх”-ийн насанд хүрсэн гишүүн, Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3, 18.2.7, 18.2.12-т заасан хүүхдийн эцэг, эх эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлтээ цахимаар гаргана.

3.3. Энэ журмын 3.2-т иргэн цахимаар хүсэлт гаргах боломжгүй бол, үйлчилгээнд хамрагдах зайлшгүй шаардлагатай боловч хамрагдаагүй өрх, иргэнийг сум, хорооны нийгмийн ажилтан үйлчилгээнд хамруулах арга хэмжээг зохион байгуулна.

3.3.1. сум, хорооны нийгмийн ажилтан нь өрхийн мэдээллийн нэгдсэн сангаас нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэний жагсаалт, Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасан үйлчилгээнд хамрагдах өрх, иргэний мэдээллийг сар бүр шинэчлэн гаргаж, үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг мэдээллээр хангана.

3.3.2. сум, хорооны нийгмийн ажилтан нь хамтарсан баг, амьжиргааг дэмжих зөвлөл, хороо, хэсгийн ахлагч, сургуулийн нийгмийн ажилтан, эрүүл мэндийн нийгмийн ажилтантай хамтран хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх эрсдэлтэй, согтуурах, мансуурах донтой иргэнтэй өрх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэнийг илрүүлж, нэн тэргүүнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авна.

Дөрөв. Үйлчилгээний нэр төрөл

4.1. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан өрх, иргэний онцлог хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн, тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасан үйлчилгээг дараах хэлбэрээр багцлан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар үзүүлнэ:

4.1.1. хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц үйлчилгээ;

4.1.2. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхөд үзүүлэх цогц үйлчилгээ;

4.1.3. ахмад настны цогц тусламж, үйлчилгээ;

4.1.4. эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх цогц үйлчилгээ;

4.1.5. хүчирхийлэлд өртсөн иргэнд үзүүлэх цогц үйлчилгээ;

4.1.6. согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэнд үзүүлэх үйлчилгээ

4.1.7. хорих ангиас суллагдсан иргэнд үзүүлэх үйлчилгээ;

4.1.8. гэр оронгүй, оршин суух тодорхой хаяггүй иргэнд үзүүлэх үйлчилгээ;

4.1.9. өрх толгойлсон эх, эцэг, тухайн өрхийн хүүхдэд чиглэсэн үйлчилгээ;

4.1.10. шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх үйлчилгээ;

4.1.11. эдгэшгүй хүнд өвчтэй иргэнд үзүүлэх үйлчилгээ;

4.1.12. нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хөдөлмөр эрхлэлт, орлогын эх үүсвэрийг дэмжих үйлчилгээ.

4.2.Энэ журмын 4.1.3-т заасан Ахмад настны цогц тусламж, үйлчилгээг Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1-т заасан журмын дагуу үзүүлж байгаа үйлчилгээтэй давхардуулахгүйгээр үзүүлнэ.

4.3.Энэ журмын 4.1.4-т заасан Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх цогц үйлчилгээг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан үйлчилгээтэй давхардуулахгүйгээр үзүүлнэ.

4.4.Хүчирхийлэлд өртсөн иргэнд үзүүлэх үйлчилгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйлчилгээтэй давхардуулахгүйгээр үзүүлнэ.

4.5 Энэ журмын 4.1.2-т заасан үйлчилгээг үзүүлэхдээ Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.8-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээтэй давхардуулахгүйгээр үзүүлнэ.

4.6.Сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ Эрүүл мэндийн байгууллагаас асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан Сэргээн засах тусламж, үйлчилгээний журамд заасан хэлбэр, дараалал, хугацаа, давтамж зэргийг баримталж, эрүүл мэндийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээтэй давхардуулахгүйгээр үзүүлнэ.

4.7.Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.9-д заасан орлогын эх үүсвэртэй болгох, төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээг зөвхөн өрхийн мэдээллийн сангаас нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай болох нь тогтоогдсон өрх, иргэнд үзүүлнэ.

4.8.Энэ журмын 4.1.1, 4.1.2-т заасан үйлчилгээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-18.1.3, 18.1.5-18.1.7, 18.1.9-д заасан үйлчилгээг, энэ журмын 4.1.5-д заасан багц үйлчилгээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 18.1.4, 18.1.10-т заасан үйлчилгээг, энэ журмын 4.1.6-4.1.8-т заасан багц үйлчилгээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-18.1.3-т 18.1.7, 18.1.8, 18.1.9-д заасан үйлчилгээг, энэ журмын 4.1.9-4.1.10-т заасан багц үйлчилгээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-18.1.2, 18.1.5, 18.1.7, 18.1.9-д, энэ журмын 4.1.11-т заасан үйлчилгээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 18.1.6-д, энэ журмын 4.1.12-т заасан үйлчилгээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2, 18.1.7, 18.1.9-д заасан үйлчилгээг тус тус багтаана.

Тав. Үйлчилгээ үзүүлэх аргачлал

5.1.Энэ журмын 4.1.1-4.1.12-т заасан багц үйлчилгээ /цаашид “үйлчилгээ” гэх/-г иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага үзүүлэхдээ Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 6949:2021 Монгол Улсын стандартын дагуу дараах шат дарааллаар үзүүлнэ:

5.1.1.нийгмийн ажилтан нь өрх, иргэний онцлог хэрэгцээ, нөөц бололцоо, нөхцөл байдлын (үйлдлийн чадамж, сэтгэл зүй, гэр бүлийн нөхцөл байдал, эдийн засгийн чадавх, амьдрах орчин, туслах хэрэгсэл, халамжийн үйлчилгээний шаардлага гэх мэт) талаар судалгааг хийх, ярилцлага авах, холбогдох бичиг баримт судлах зэргээр мэдээлэл цуглуулан, үйлчилүүлэгчийн асуудлын шалтгаан нөлөөллийг шинжлэн **нөхцөл байдлын үнэлгээ хийх**;

5.1.2.өрх, иргэний хэрэгцээнд нийцсэн урт, богино хугацааны зорилгыг тодорхойлон кейс менежментийн **төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх үе шат хугацааг төлөвлөх;**

5.1.3.энэ журмын 5.1.2-т заасан төлөвлөгөөний дагуу **үйлчилгээг үзүүлэх;**

5.1.4.энэ журмын 5.1.3-т заасан үйлчилгээнээс бусад буюу яаралтай тусламж, нарийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх шаардлагатай тохиолдолд холбогдох нийгмийн үйлчилгээний байгууллагад өрх, иргэнийг **холбон зуучилж, хамтран ажиллах;**

5.1.5.төлөвлөсөн зорилтуудын хэрэгжилтийг төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа **эсэхийг хянах** (өрх, иргэнтэй хийх уулзалтыг баримтжуулах үүнд уулзалтын сэдэв, ярилцлагын товч тэмдэглэл, шийдвэр, үйлчилүүлэгчийн нөхцөл байдал, санал хүсэлт болон дараагийн хийгдэх үйлчилгээний алхамыг тус тус багтаах);

5.1.6.өрх, иргэний үйлчилгээнд хамрагдах хугацаанд цугласан баримт бичгийг нэгтгэн хувийн **хэрэгт хавсаргах, цахим мэдээллийн санд бүртгэх;**

5.1.7.үйлчилгээг дараах **үндэслэлээр хаах;**

5.1.7.1.өрх, иргэн кейс төлөвлөгөөний дагуу үйлчилгээнд бүрэн хамрагдаж, үйлчлүүлэгчтэй зөвшилцөн, цаашид бие даан асуудлаа шийдвэрлэх зөвөлгөө өгсөн;

5.1.7.2.өрх, иргэн нас барсан;

5.1.7.3.өрх, иргэний өөрийн хүсэлтээр эсхүл өрх, иргэн шилжсэн, өөр байгууллагаас үйлчилгээ авахаар болсон зэрэг сум, хорооны нийгмийн ажилтны тодорхойлолтод үндэслэсэн;

5.1.8.өрх, иргэний кейсийг хаахад сум, хорооны нийгмийн ажилтанд танилцуулж, зөвшилцөх.

5.2.Нийгмийн ажилтан нь өрх, иргэнд үйлчилгээ үзүүлэхдээ зөвлөгөө өгөх, хувь хүн, гэр бүлийг дэмжих, сургалт, боловсролын, холбон зуучлах, нийгэмд дасан зохицоход туслах, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн, олон нийтийн хөгжлийн зэрэг үйлчилгээг өөрийн байгууллагын болон тухайн орон нутгийн нөөц, бололцоонд суурилан үзүүлнэ.

5.3.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнд хувцас, хүнс зэргийг цуглуулах, тараах, хандивын хайрцаг ажиллуулах, нөлөөллийн аян зохион байгуулах, усанд оруулах, үс засах, эмчийн үзлэгт хамруулах зэрэг сайн дурын үйл ажиллагаанд холбогдох байгууллага, хувь хүн, сайн дурын ажилтан, оюутныг татан оролцуулж, хамтран зохион байгуулна.

5.4.Сум, хорооны нийгмийн ажилтан нь дараах тохиолдолд өрх, иргэний үйлчилгээг зогсооно:

5.4.1.үйлчилгээнд хамрагдаж буй иргэн нас барсан;

5.4.2.хуурамч баримт бичиг бүрдүүлэн үйлчилгээнд хамрагдсан буюу хамруулсан нь хяналт, шалгалтаар тогтоогдсон;

Зургаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц үйлчилгээ үзүүлэх заавар

6.1.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын нийгмийн ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц үйлчилгээ үзүүлэхдээ энэ журмын 5.1.1-д заасны дагуу үнэлгээ хийж, хөгжлийн бэрхшээлтэй хүний бэрхшээлийн зэргийг тодорхойлон, “хөнгөн, дунд”, “хүнд буюу байнгын асаргаа зайлшгүй шаардлагатай” гэж ангилан тохирох үйлчилгээнд хамруулна.

6.2.“Хөнгөн, дунд” гэж үнэлэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь өдөр тутмын амьдралд тодорхой түвшинд хязгаарлалт үүсдэг ч гэр бүл, бусдын тусламжтайгаар ажиллах, суралцах, нийгмийн харилцаанд оролцох боломжтой байх бөгөөд үйлчилгээг дараах хэлбэрээр үзүүлнэ:

6.2.1.нийгмийн оролцоо, хөгжлийг дэмжих үйлчилгээ (зөвлөгөө, сургалт);

6.2.2.орлогын эх үүсвэрийг дэмжих төсөл хэрэгжүүлэх үйлчилгээ.

6.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний **нийгмийн оролцоо, хөгжлийг дэмжих** зорилгоор мэдээлэл, зөвлөгөө, сургалтыг дараах байдлаар үзүүлнэ:

6.3.1.хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд тохирсон,тэгш хүртээмжтэй мэдлэг мэдээллээр хангаж, шаардлагатай үйлчилгээ, тусгай хэрэгцээнд (протез, ортопед) холбон зуучлах;

6.3.2.хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хэрэгцээтэй зөвлөгөө өгөх үйлчилгээг иргэн, аж ахуй нэгж, төрийн бус байгууллагын орон тооны (мэргэжлийн ажилтангүй бол гэрээлэн ажиллуулж болно), мэргэжлийн гэрчилгээтэй хуульч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан болон бусад нарийн мэргэжилтэн үзүүлэх.

6.3.3.хөгжлийн бэрхшээлтэй иргэний **нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд** чиглэсэн сургалтын үйлчилгээг дараах хэлбэрээр үзүүлнэ:

6.3.3.1.**бие даан амьдрах чадвар, боловсролыг дэмжих:** мэргэжил олгох сургалт, дамжаа, насан туршийн суралцахуйн төвд холбон зуучлах, бие даан амьдрахад туслах (хоол хийх, ахуйн ажилд туслах, өөрт тохирсон өдөр бүрийн хуваарь гаргах, хувийн санхүүгийн төлөвлөгөө, бие даан нийтийн тээврээр зорчих, аюулгүйн төлөвлөгөө, анхан шатны тусламж) чиглэлээр сургалт зохион байгуулах;

6.3.3.2.**хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх:** төсөл санаачлах, хэрэгжүүлэхэд туслах (төсөл бичих, хэрэгжүүлэх арга зүй, шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх) сургалт зохион байгуулах, ажлын байранд өөрийгөө бэлтгэхэд туслах (хөдөлмөр эрхлэх нөөц бололцоог хамтран тодорхойлох, ажлын ярилцлагад бэлтгэх, цалин, нийгмийн даатгал тооцоолох, ажлын байрны ёс зүй) сургалт зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр гэрээлэн ажиллаж буй байгууллагад холбон, сургалтад хамруулах;

6.3.3.3.**нийгмийн оролцоог дэмжих:** сонирхол нэгтэй хүмүүстэй бүлэг болж хамтран ажиллахад туслах зорилгоор дэмжих бүлэг зохион байгуулах, сайн дурын ажил, олон нийтийн үйл ажиллагаанд холбон зуучлах, харилцааны ур чадварыг нэмэгдүүлэх (өөрийгөө илэрхийлэх, зөрчлийг шийдвэрлэх арга зүй, олон нийтийн өмнө үзэл бодлоо илэрхийлэх) чиглэлээр сургалт зохион байгуулах;

6.3.3.4.**технологийн хэрэгсэл ашиглахад туслах:** орчин үеийн техник хэрэгсэл, компьютер, гар утас, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл ашиглах,

нийгмийн сүлжээ, цахим хуудаснаас өөрт хэрэгтэй мэдээлэл, үйлчилгээг авах талаар зөвлөгөө, сургалт зохион байгуулах.

6.4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний **орлогын эх үүсвэрийг дэмжихэд чиглэсэн төсөл санаачлах, хэрэгжүүлэх** үйлчилгээг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

6.4.1.хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй мэргэжил, сургалтын байгууллагад холбон зуучлах;

6.4.2.хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай тоног, төхөөрөмж, нөөц боломжийг хамтран судлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд холбон зуучлах;

6.4.3.нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.9-т заасны өрхийн гишүүн-иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох, төсөлд хамруулах;

6.4.4.төсөл бичих, хэрэгжүүлэх арга зүй, сонгон шалгаруулалт, мэдээлэл, сургалт, сурталчилгааг Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулна.

6.5.“хүнд” гэж үнэлэгдсэн буюу бие даан амьдрах боломжгүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дараах үйлчилгээг үзүүлнэ:

6.5.1.сэргээн засах үйлчилгээ;

6.5.2.өдрийн үйлчилгээ;

6.5.2.гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах.

6.6.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний **сэргээн засах үйлчилгээг** дараах байдлаар үзүүлнэ:

6.6.1.хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ Эрүүл мэндийн байгууллагаас асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан Сэргээн засах тусламж, үйлчилгээний журамд заасан хэлбэр, дараалал, хугацаа, давтамж зэргийг баримтлах;

6.6.2.иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь энэ журмын 6.6.1-д заасан байгууллагад сэргээн засах үйлчилгээ шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг холбон зуучлах.

6.7.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний **өдрийн үйлчилгээг** иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага өөрийн (түрээсийн) байранд дараах байдлаар үзүүлнэ:

6.7.1.өдрөөр асрах үйлчилгээний хугацаа, үйлчлүүлэгчийн хооллолт, үзүүлэх асаргаа, сувилгааны үйлчилгээний төрөл, хэлбэрийг түүний эрүүл мэндийн байдал, хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулж, хувь хүний хөтөлбөрийн дагуу асаргаа үйлчилгээний болон хөгжлийн үйлчилгээ үзүүлэх;

6.7.2.өдөр тутмын арчилгаа: хооллох, хувцаслах, ариун цэвэр сахихад туслах, хэвтрийн горимд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг шилжүүлэн

байрлуулах, хөдөлгөөнд дэмжлэг үзүүлэх, тэргэнцэр ашиглахад туслах;

6.7.3.асаргаа, сувилгааны үйлчилгээ: хөнгөн дасгал хөдөлгөөн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний биеийн болон оюун санааны үйл ажиллагааг идэвхжүүлэх, эм уухад туслах, биеийн байдлыг хянах, шаардлагатай тохиолдолд анхны тусламж үзүүлэх;

6.7.4.сэтгэл санааны дэмжлэг:тусгайлан бэлтгэгдсэн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, онцлогт суурилан сэтгэл санааг нь дэмжих, бие даан сонирхож буй үйл ажиллагааг дэмжихэд (ном унших, зураг зурах) чиглүүлэх.

6.7.5.хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэнд үзүүлэх дэмжлэг:

6.7.5.1.сэтгэл санааны дэмжлэг: асрахуйн ачаалалтай холбоотой сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ижил туршлагатай хүмүүсээс бүрдсэн дэмжих бүлэг (биеэр болон онлайн хэлбэрээр) зохион байгуулах, мэргэжлийн сэтгэл зүйчтэй уулзуулах зэргээр асран хамгаалагчийн сэтгэл зүйн сайн сайхан байдлыг дэмжих;

6.7.5.2.асрамжлах үйлчилгээний ур чадвар дээшлүүлэх: хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог, хэрэгцээнд суурилсан асрамжлах үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай ур чадвар (эрүүл мэндийн анхан шатны арчилгаа, хөдөлгөөний дэмжлэг, эрүүл амьдралын хэв маяг, зөв хооллолт, харилцааны арга зүй, анхан шатны тусламж) олгох сургалтад хамруулах;

6.7.5.3.арга зүйн дэмжлэг: хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асрахад шаардлагатай тоног төхөөрөмж, тусгай хэрэгсэл (тэргэнцэр, протез, ортопед, сонсголын аппарат, брайль хэвлэл) –ийг ашиглахад туслах арга зүйн зөвлөгөө, сургалтад хамруулах;

6.7.5.4.уян хатан хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх: асрахуйн ачаалалтай холбогдуулан уян хатан цагаар ажил эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, өөрийн цагийн хуваарьт тохирсон бүтэн болон хагас цагийн ажилд холбон зуучлах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

6.8.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэрт нь очиж дараах байдлаар хэрэгжүүлнэ:

6.8.1.өдөр тутмын ахуйн үйл ажиллагаанд туслах: хоол хүнс бэлтгэх, дэлгүүрээс хүнс, бараа худалдан авахад дэмжлэг үзүүлэх, гэр орны цэвэрлэгээ, угаалга, хувцас индүүдэх зэрэг ажлыг гүйцэтгэх, хувийн ариун цэврийг сахихад туслах (усанд оруулах, шүд, гар нүүр угаах, хувцас өмсгөх гэх мэт), хооллох, бие засуулах, мод түлээ хагалах, ус авах, зэргээр бие даан амьдрахад хүндрэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд аюулгүй, тав тухтай орчин бүрдүүлэх;

6.8.2.нийгмийн харилцааг дэмжих: өөрийгөө илэрхийлэх, гэр бүлийн гишүүдтэйгээ харилцахад нь туслах, гар, хөлийн хөдөлгөөн сайжруулахад туслах, гэрийн орчны аюулгүй байдлыг шалгах (цахилгаан хэрэгсэл, шат гишгүүрийн аюулгүй байдал гэх мэт), осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх,

хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг захиалах, хүргүүлэхэд туслах, байгууллага, үйлчилгээний газруудтай холбогдож, асуудлыг шийдвэрлэхэд зуучлах.

6.8.3.энэ журмын 6.7.5-д заасан үйлчилгээг байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэнд үзүүлэх.

6.9.Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9-т заасны дагуу хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд асаргаа, сувилгааны болон асрамжлах үйлчилгээний ур чадварыг дэмжих сургалтыг зохион байгуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.

Долоо. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхөд цогц үйлчилгээ үзүүлэх заавар

7.1.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхөд дараах үйлчилгээг үзүүлнэ:

7.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах, хөгжих эрхийг дэмжих үйлчилгээ (сургалт, зөвөлгөө);

7.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээ;

7.1.3.сэргээн засах үйлчилгээ;

7.1.4.өдрийн үйлчилгээ;

7.1.5.гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ.

7.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах, хөгжих эрхийг дэмжих үйлчилгээг хүүхдийн тусгай хэрэгцээ, онцлогт нийцүүлэн багш, нийгмийн ажилтан бэлтгэсэн хөтөлбөрийн дагуу дараах байдлаар үзүүлнэ:

7.2.1.**хөдөлгөөний чадварыг дэмжих:** алхах, тэнцвэрээ хадгалах, хөдөлгөөн сайжруулах дасгалууд, гар болон хурууны ур чадварыг хөгжүүлэх (бичих, хоолоо идэх, хувцасаа өмсөх, товчоо товчлох гэх мэт), хүүхдийн биеийн чадварт тохирсон бүжиг, иог, булчин суллах дасгалд хамруулах;

7.2.2.**танин мэдэхүйн ур чадварыг дэмжих:** анхаарал төвлөрүүлэх, амьсгалын дасгал, эвлүүлдэг, ой тогтоолтыг дэмжих тоглоом, сэтгэн бодох, өөрөө бие даан суралцах, шийдвэр гаргахад туслах, сэтгэл хөдлөлөө таних, нэрлэх сургалтад хамруулах;

7.2.3.**харилцаа, хэл, ярианы ур чадварыг дэмжих:** бусадтай харилцах, өөрийгөө илэрхийлэх, мэндлэх, асуулт асуух, үгийг зөв, тод дуудах, харилцан яриа өрнүүлэх, дохионы хэл ашиглах талаарх зөвлөгөө, сургалтад хамруулах;

7.2.4.**нийгмийн оролцоог дэмжих:** найзлах, нөхөрлөх, хамтын ажиллагаа, багийн ур чадварыг хөгжүүлэх, олон нийтийн үйл ажиллагаанд туслах, оролцох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох талаарх сургалтад хамруулах;

7.2.5.**сургууль (цэцэрлэг)-д дасан зохицоход туслах:** хичээлийн хоцрогдол арилгах, тоо бичиг, үсэг заах, брайль, том үсэгтэй текст, аудио материал ашиглахад туслах, сургуулийн орчинд дасан зохицох, анги танхим, зай талбайн

хүртээмж, байршлыг тодорхойлох, багш болон бусад сурагчидтай харилцахад туслах зөвлөгөө, сургалт үзүүлэх;

7.2.6.бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд туслах: зураг зурах, хөгжмийн зэмсэг тоглох, гар урлал, наамал, эсгий урлал зэрэг урлаг, тоглоомын аргаар дамжуулан хүүхдийн бүтээлч чадвар, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх сургалтад хамруулах.

7.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааг сайжруулах, гэр бүлийн гишүүдийн сэтгэл зүй, өрхийн орлогыг дэмжих зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээг дараах байдлаар үзүүлнэ:

7.3.1.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих: хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд холбон зуучлах, өрхийн бизнес эрхлэх, төсөл бичих, төсвийн төлөвлөгөө гаргах, ажлын байр, бусад уян хатан нөхцөлөөр хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх байгууллагад холбон зуучлах;

7.3.2.хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэг нэмэгдүүлэх: хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, шинж чанар, хөгжлийн бэрхшээлийн төрөл, үр нөлөөний талаарх мэдлэг, ойлголт нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөөнд хамруулах;

7.3.3.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах чиглэлийн сургалт: хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хооллох, хувцаслах, хөдөлгөөнд нь туслах, өөрийгөө илэрхийлэх, бие даах чадварыг хөгжүүлэх, аюулгүй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх, хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйлийг ойлгоход туслах сургалтад хамруулах;

7.3.4.сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх дэмжих бүлэг байгуулах: хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхийн гэр бүлийн гишүүдийн стресс, сэтгэл зовиол, хүүхэд асрахтай холбоотой бэрхшээлийг даван туулахад туслах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхүүдээс бүрдсэн дэмжих бүлгийг зохион байгуулах;

7.3.5.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй мэргэжилтнүүдэд чиглэсэн дараах үйлчилгээ үзүүлнэ:

7.3.5.1.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг дэмжих: хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүй, арга барил олгох сургалтад хамруулах;

7.3.5.2.тэгш, хүртээмжтэй орчинг бүрдүүлэхэд туслах: хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, зай талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээнд тэгш хамруулах, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх талаарх нөлөөллийн ажил, зөвлөгөө, сургалт зохион байгуулах;

7.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдэд үзүүлэх сэргээн засах үйлчилгээг энэ журмын 6.6, өдрийн үйлчилгээг 6.7, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг 6.8-д заасны дагуу үзүүлнэ.

**Найм.Хүчирхийлэлд өртсөн иргэнд үзүүлэх
цогц үйлчилгээ үзүүлэх заавар**

8.1.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь хүчирхийлэлд өртсөн иргэнд үйлчилгээ үзүүлэхдээ Хохирогч түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS6040:2019 Монгол Улсын стандартын дагуу үзүүлнэ.

9.Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэнд үзүүлэх үйлчилгээ үзүүлэх заавар

9.1.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь согтуурах, мансуурах донтой өвчтэй иргэний биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, тогтворжуулах, донтолт, сөрөг зан үйлээ даван туулахад нь туслах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор үйлчилгээг дараах хэлбэрээр үзүүлнэ:

9.1.1.анхан шатны үнэлгээ, зөвлөгөө, холбон зуучлах үйлчилгээ;

9.1.2.зан үйлд нөлөөлөх сургалт, дэмжих бүлэг зохион байгуулах;

9.1.3.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ;

9.1.4.сэргээн засах үйлчилгээ.

9.2.Согтуурах, мансуурах донтой өвчтэй иргэнд **анхан шатны үнэлгээ, зөвлөгөө, холбон зуучлах** үйлчилгээг дараах байдлаар үзүүлнэ:

9.2.1.иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын нийгмийн ажилтан согтуурах, мансуурах донтой өвчтэй иргэний архи, мансууруулах бодисын хэрэглээ, хэмжээ, давтамжийн талаарх **анхан шатны үнэлгээг хийнэ**;

9.2.2.архи, мансууруулах бодисын хэрэглээний улмаас үүссэн хоол тэжээлийн дутагдал, бие махбодын өөрчлөлт, сэтгэл зүйн байдал, архи, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэсний улмаас үүссэн гэр бүл, ойр дотны гишүүдэд гарсан сөрөг нөлөөлөл, **эрсдлийг тодорхойлно**;

9.2.3.нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай согтуурах, мансуурах донтой өвчтэй иргэнд **анхан шатны тусламж** (хоол хүнс, түр хоноглох байр, хувцас хэрэглэл, ариун цэврийн хэрэглэл, усанд оруулах, сайн дурын эрүүл мэндийн үзлэг, баримт бичиг бүрдүүлэх) үйлчилгээнд хамруулж, холбон зуучлах;

9.2.4.архи, мансууруулах бодист донтох эмгэгийн шинж тэмдэг, үр дагавар, эмчилгээний талаар тайлбарласан, шинжлэх ухааны үндэслэлтэй **мэдээлэл, зөвлөгөөг** согтуурах, мансуурах донтой өвчтэй иргэн болон түүний гэр бүлийн гишүүдэд үзүүлнэ;

9.2.5.архинд донтох эмгэгийн эмчилгээ, үйлчилгээний талаар мэргэжлийн байгууллага (Нийслэлийн Аддиктологийн төв), эмнэлгийн тусгай дугаар (Нийслэлийн Наркологийн эмнэлгийн тусгай дугаар 1800-1893), мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагад **холбон зуучилна**.

9.3.Согтуурах, мансуурах донтой өвчтэй иргэнд **зан үйлд нөлөөлөх сургалт, дэмжих бүлэг зохион байгуулах үйлчилгээг** дараах хэлбэрээр үзүүлнэ:

9.3.1.**зан үйлд нөлөөлөх сургалт:** архи, мансууруулах бодист донтох зан үйлээ өөрчлөхөд туслах мэргэжлийн гэрчилгээтэй эмч, сэтгэл зүйч, нийгмийн

ажилтны сургалтад үе шаттайгаар хамруулах, архи, мансууруулах бодис хэрэглэхэд нөлөөлж буй суурь шалтгаан, донтох сэдлээ тодорхойлоход нь туслах сэдэлжүүлэх ярилцлагад хамруулах;

9.3.2.дэмжих бүлэг зохион байгуулах (Alcoholics Anonymous): согтуурах, мансуурах эмгэгийг даван туулж буй туршлагаа хуваалцах, ижил асуудалтай иргэний түүхийг сонсох, өөрийгөө хянах, удирдахад дэмжлэг үзүүлэх зорилгоор согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэнд дэмжих бүлгийг тогтмол зохион байгуулах;

9.3.3.нийгмийн оролцоог дэмжих, гэр бүл, ойр дотны хүмүүстэй харилцах харилцааг сайжруулах сургалт: уур бухимдал, стресс тайлах аргууд, гэр бүлийн харилцаагаа сэргээх, эерэг хүмүүжлийн аргууд, жендэрийн эрх тэгш байдал, хүүхэдтэйгээ харилцах арга зүй, сайн эцэг эх, харгалзан дэмжигч байх, мөн гэр бүлийн гишүүдийг согтуурах, мансуурах донтой өвчтэй иргэнийг донтолтоос гаргахад туслах, дэмжих сургалтад хамруулах;

9.4.Согтуурах, мансуурах бодист донтох өвчтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг дараах хэлбэрээр үзүүлнэ:

9.4.1.согтуурах, мансуурах бодист донтох өвчтэй иргэний ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хувь хүний хүсэл сонирхол, онцлогт нийцсэн мэргэжил олгох сургалт, курс, мэргэжил сургалтын төв, насан туршийн суралцахуйн төвд холбон зуучлах;

9.4.2.хөдөлмөр эрхлэх боломж, сул орон тоо, ажлын байрны талаарх мэдээллийг хэрхэн хайх, харъяа аймаг, дүүрэг, сум, хорооны хөдөлмөрийн асуудал хариуцсан нэгжтэй холбогдоход туслах, зөвлөгөө мэдээлэл хүргэх;

9.4.3.жигжиг, дунд бизнес эрхлэхэд шаардлагатай төсөл бичих, санхүүжилт босгох, бизнесийн төлөвлөгөө гаргах, төсөл хэрэгжүүлэх талаарх сургалт, зөвлөгөөнд хамруулах.

9.5.Согтуурах, мансуурах бодист донтох өвчтэй иргэнийг хор тайлах зэрэг эмнэлгийн тусламж үйлчилгээнд холбон зуучилж, мэргэжлийн эмчийн онош, хяналт дор эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлнэ.

9.6.Согтуурах, мансуурах бодист донтох өвчтэй иргэнд сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ Эрүүл мэндийн байгууллагаас асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан Сэргээн засах тусламж, үйлчилгээний журамд заасан хэлбэр, дараалал, хугацаа, давтамж зэргийг баримтална.

9.7.Согтуурах, мансуурах бодист донтох өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлт бүлэг, өрх иргэнийг тодорхойлох, тэдэнд сургалт, зөвлөгөө, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, дэмжих бүлэг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд холбон зуучлана.

9.8.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь согтуурах, мансуурах бодист донтох өвчний үйлчилгээ авсан иргэнийг эрсдлээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хянах чадварыг нэмэгдүүлэх, нийгэмд дасан зохицох, хамт олон гэр бүлтэй харилцах харилцааг сэргээх, эрүүл амьдралын хэв маяг төлөвшүүлэх,

хөдөлмөр эрхлүүлэх зэргээр дэмжлэг үзүүлж, эргэн хянах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Арав. Хорих ангиас суллагдсан иргэнд үзүүлэх үйлчилгээ үзүүлэх заавар

10.1.Энэ журмын 4.5-д заасан багц үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага хорих ангиас суллагдсан иргэнд дараах хэлбэрээр үзүүлнэ:

10.1.1.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ;

10.1.2.нийгэмд дасан зохицоход туслах сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээ.

10.2.Хорих ангиас суллагдсан иргэний **хөдөлмөр эрхлэлтийг дэмжих** үйлчилгээг дараах байдлаар үзүүлнэ:

10.2.1.ажлын байр, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, дамжаа, боловсролын байгууллагад **холбон зуучлах**;

10.2.2.ажлын байранд бэлтгэх, өргөдөл гаргах, ярилцлагад бэлтгэх, төсөл бичих, тогтвортой хөдөлмөр эрхлэхийн давуу тал зэргийг багтаасан **сургалтад хамруулах**.

10.3.Хорих ангиас суллагдсан иргэнийг **гэмт хэргээс ангид байх нөхцлийг бүрдүүлэх, нийгэмд дасан зохицоход туслах үйлчилгээг** дараах байдлаар үзүүлнэ:

10.3.1.**хөгжил, ур чадварыг дэмжих сургалт**: сэтгэл зүйгээ удирдах, өөрт буй нөөц боломжоо тодорхойлох, өөрийн давуу тал, ур чадварт суурилсан цаашдын төлөвлөгөө гаргах зэргээр дахин гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх, бичиг үсгийн боловсрол олгох сургалтад хамруулах;

10.3.2.**санхүүгийн мэдлэг олгох сургалт**: хувийн санхүүгийн төлөвлөгөө, зах зээлийн өртөг, өөрчлөлт, цалин, урамшуулал бодох аргачлал, жижиг бизнес эрхлэх, төсөл хэрэгжүүлэх, хуримтлал үүсгэхэд туслах зөвлөгөө, сургалтад хамруулах;

10.3.3.**технологийн сургалт**: цахим орчны аюулгүй байдал, технологийн хэрэгсэл ашиглан өөрт хэрэгтэй мэдээлэл, үйлчилгээг авахад туслах зөвлөгөө, сургалтад хамруулах;

10.3.4.**нийгмийн оролцоо, гэр бүлийн харилцааг дэмжих сургалт**: нийгэмд чиглэсэн сайн дурын үйлчилгээ, олон нийтийн үйл ажиллагаанд холбон зуучлах, гэр бүл, найз нөхөд, ойр дотны хүмүүстэй харилцаагаа эргэн сэргээх, хүүхэдтэйгээ харилцах эерэг хүмүүжлийн аргуудын талаарх зөвлөгөө, сургалтад хамруулах.

10.4.Хорих ангиас суллагдсан иргэнд шаардлагатай баримт бичиг, орон байр, эрүүл мэндийн үйлчилгээ, сүрьеэгийн илрүүлэг зэрэг шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучилна.

10.5.**Сургалт хүмүүжлийн тусгай төвөөс суллагдсан өсвөр насны хүүхдэд** энэ журмын 9.3-т заасан үйлчилгээг хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохируулан үзүүлэх, мөн хөгжлийг дэмжих, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, нийгмийн оролцоог сайжруулах, дахин гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан

сэргийлэх, нийгмийн ялгаварлал гадуурхалаас хамгаалах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Арван нэг. Гэр оронгүй, оршин суух тодорхой хаяггүй иргэнд үзүүлэх үйлчилгээ үзүүлэх заавар

11.1.Гэр оронгүй, оршин суух тодорхой хаяггүй иргэнийг түр хоноглох байраар хангах, хоол тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх, орон байр, орлогын эх үүсвэртэй болоход туслах зорилгоор дараах үйлчилгээг үзүүлнэ:

11.1.1.нөхцөл байдлын үнэлгээ;

11.1.2.түр хоноглох орон байраар хангах үйлчилгээ;

11.1.3.согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэнд үзүүлэх үйлчилгээ;

11.1.4.орлогын эх үүсвэр, орон байр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ.

11.2.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын нийгмийн ажилтан гэр оронгүй, оршин суух тодорхой хаяггүй иргэний **нөхцөл байдлын үнэлгээг** дараах байдлаар хэрэгжүүлнэ:

11.2.1.бие махбод болон сэтгэл зүйн байдлыг үнэлэн архи, мансууруулах бодисын хамаарал, сэтгэл заслын нэмэлт үйлчилгээ авах хэрэгцээтэй эсэхийг тодорхойлон, мэргэжлийн байгууллагад холбон зуучилж, хамтран ажиллах;

11.2.2.нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай гэр оронгүй, оршин суух тодорхой хаяггүй иргэнд анхан шатны тусламж (бичиг баримтжуулах, хоол хүнс, түр хоноглох байр, дулаан хувцас хэрэглэл, ариун цэврийн хэрэглэлээр хангах, усанд оруулах, эрүүл мэндийн үзлэг, сүрьеэ зэрэг халдварт өвчний илрүүлэг гэх мэт) үйлчилгээнд хамруулж, холбон зуучлах;

11.2.3.одоогийн нөхцөл байдал, гэр орны талаарх мэдээллийг дараах асуулгын дагуу үнэлнэ: Та хамгийн сүүлд хаана оршин сууж байсан бэ?, Та хэр хугацаанд тэр газар амьдарсан бэ?, Та тэр газраас явах болсон шалтгаан юу вэ?, Ямар шалтгааны улмаас гэр оронгүй болсон бэ?, Та амьдралдаа хэдэн удаа гэр оронгүй болж байсан бэ?, Таныг богино хугацаанд хоноглуулах, мөнгө зээлэх найз нөхөд, хамаатан садан, гэр бүл бий юу?, Танд яг одоо орлогын эх үүсвэр бий юу?, Танд эрүүл мэндийн ямар зовиур байна вэ?.

11.2.4.нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийсний дараа гэр оронгүй, оршин суух тодорхой хаяггүй иргэнд үзүүлэх үйлчилгээ, хэр хугацаанд түр хоноглох байранд байрлах талаар кэйс төлөвлөгөөнд тусган, ажиллана.

11.3.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь түр хоноглох байранд гэр оронгүй, оршин суух тодорхой хаяггүй иргэнийг кэйс төлөвлөгөөний дагуу байршуулна.

11.3.1.асрамжийн үйлчилгээнд байнга асруулах шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн бол асрамжийн газарт холбон зуучлах;

11.3.2.өөрийн хүсэлтээр тогтмол байрлаж, цаашид бие даан амьдрах сонирхолтой, гэр оронгүй иргэнийг хөдөлмөрт зуучлах, хөнгөлттэй орон сууцанд зуучлах, урт хугацаанд түр байршуулах.

11.4.Түр хоноглох байрны үйл ажиллагаа, дотоод журам, хоол хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг Стандарт хэмжил зүйн байгууллагаас баталсан Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй нийтлэг шаардлагад нийцүүлнэ.

11.5.Гэр оронгүй, оршин суух газаргүй иргэн, өрхийн сэтгэл зүйн байдлыг тогтворжуулах, гэр оронгүй болсны улмаас үүссэн үр дагаварыг хамтран тодорхойлж, тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг даван туулах, зан хандлагыг нь өөрчлөхөд чиглэсэн сургалтад хамруулна.

11.6.Гэр оронгүй, оршин суух тодорхой хаяггүй иргэн нь согтуурах, мансуурах донтох өвчтэй бол энэ журмын 8.1-т заасан үйлчилгээг 8.2-т заасны дагуу үзүүлнэ.

11.7 Гэр оронгүй, оршин суух тодорхой хаяггүй иргэний **орлогын эх үүсвэр, орон байр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг** дараах байдлаар үзүүлнэ:

11.7.1.ажлын байр, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, дамжаанд холбон зуучлах, орлогын эх үүсвэртэй болоход туслах зөвлөгөө, сургалтад хамруулах, баримт бичиг, өргөдөл гаргах, материал бүрдүүлэхэд туслах;

11.7.2.төрийн байгууллага, олон улсын байгууллага, нийгмийн сайн сайхны төлөө хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрөөр дамжуулан өөрийн болон түрээсийн орон байртай болоход холбон зуучлах;

11.7.3.нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.9-д заасан нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгоход туслах төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Арван хоёр. Өрх толгойлсон эх, эцэг, тухайн өрхийн хүүхдэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх заавар

12.1.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь өрх толгойлсон эх, эцэг, тухайн өрхийн хүүхдэд дараах хэлбэрийн үйлчилгээг үзүүлнэ:

12.1.1.өрхийн хүүхдэд чиглэсэн хөгжлийг дэмжих өдрийн үйлчилгээ;

12.1.2.өрх толгойлсон эх, эцгийн нийгмийн оролцоог дэмжих үйлчилгээ (сургалт, зөвлөгөө);

12.1.3.өрх толгойлсон эх, эцгийн орлогын эх үүсвэр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ;

12.2.Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн **хүүхдэд чиглэсэн хөгжлийг дэмжих өдрийн үйлчилгээг дараах байдлаар үзүүлнэ:**

12.2.1.хүүхдийг өдрийн үйлчилгээнд хамруулах: хүүхдийг сурч хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор тохь, тухтай дулаан орчинд гэрийн даалгавараа хийх, хичээлийн хоцрогдол арилгах, уншлагын дугуйлан, харилцааны ур чадвар, багаар ажиллах, илтгэл тавих гэх мэт өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, хувийн ариун цэвэр сахих, цаг төлөвлөлт, гар урлал, урлаг, дуу хөгжим, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, дасгал хөдөлгөөнийг нэмэгдүүлэх сургалтуудад хамруулах.

12.3.Өрх толгойлсон эх, эцгийн **нийгмийн оролцоог дэмжихэд** дараах байдлаар үйлчилгээ үзүүлнэ:

12.3.1.хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүртээмж, хүүхэд асрахтай холбоотой ачааллыг хэрхэн зохицуулах талаарх зөвлөгөө, мэдээлэл өгөх;

12.3.2.хүүхдийн тэтгэмж тогтоолгох, шүүхэд өргөдөл, нэхэмжлэх гаргах, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хуулийн зөвлөгөөнд хамруулах;

12.3.3.хүүхдийг хоол тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчинд өсгөх, эерэг хүмүүжлийн аргууд, хүүхдийн боловсрол, нас сэтгэл зүйн онцлогийн талаар сургалтад хамруулах;

12.3.4.сэтгэл зүйн сайн сайхан байдлаа нэмэгдүүлэхэд туслах (өөрийгөө хайрлах, сэтгэл хөдлөлөө танин мэдэх, ганцаардлыг даван туулах, харилцааны ур чадвар, тайвшруулах дасгалууд, эрүүл аж төрөхтэй холбоотой гэх мэт) сургалт, зөвлөгөө, дэмжих бүлэгт хамруулах.

12.4.Өрх толгойлсон эх, эцгийн **орлогын эх үүсвэр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих** үйлчилгээг дараах байдлаар үзүүлнэ:

12.4.1.ажлын байранд зуучлах, уян хатан нөхцөлтэй ажилд ороход туслах талаарх зөвлөгөө, мэдээлэл хүргэх;

12.4.2.гэрээсээ ажиллах боломжтой ажлын байрны талаарх мэдээлэл, жижиг бизнес, төсөл санаачлахад туслах зөвлөгөө, өөрийн нөөц, бололцоонд суурилсан хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэхэд туслах бусад сургалтад хамруулах;

12.4.3.ижил зорилго, нөхцөлтэй бусад өрх, гишүүдийг нэтгэн дэмжих бүлэг ажиллуулах, хамтран төсөл, бизнесийн санаа гаргахад туслах;

12.4.4.өрхийн санхүүгийн төлөвлөгөө боловсруулах, бусад тусламж, дэмжлэгийн талаарх мэдээлэл хүргэх, хүүхдийн мөнгө, нийгмийн халамжийн тусламжийг үр дүнтэй зарцуулахад туслах зөвлөгөө, сургалтад хамруулах.

Арван гурав. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх үйлчилгээ үзүүлэх заавар

13.1.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь шилжин суурьшсан, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд дараах хэлбэрээр үйлчилгээ үзүүлнэ:

13.1.1 зөвлөгөө өгөх;

13.1.2.шинэ орчинд дасан зохицоход туслах үйлчилгээ(сургалт);

13.1.3.ажилд зуучлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ;

13.1.4.хүүхдийн хөгжлийг дэмжих өдрийн үйлчилгээ.

13.2. Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд дараах **зөвлөгөөг** үзүүлнэ:

13.2.1.өрх, гэр бүлийн гишүүдийн мэдээлэл, бүртгэл, шилжилттэй холбоотой хууль эрх зүйн зөвлөгөө;

13.2.1.шилжин суурьшсан өрхийн хүүхдийн боловсролын байгууллагад бүртгүүлэхэд шаардлагатай зөвлөгөө;

13.2.1.байнгын эсхүл түрээсийн гэр, хөнгөлттэй орон сууцанд хамрагдах, өргөдөл гаргах, бичиг баримт бүрдүүлэх зөвлөгөө;

13.2.4.шилжин суурьшсантай холбоотой бусад бичиг баримт, өмчлөл, эрүүл мэнд, санхүү, хууль зүй болон нийгмийн халамжийн зөвлөгөө.

13.3.Шилжин суурьшсан өрх, иргэнд **шинэ орчинд дасан зохицохтой** холбоотой дараах сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулна:

13.3.1.шилжин суурьшсан орон нутгийн талаарх мэдээлэл олгох сургалт (тухайн бүс нутгийн онцлог, орон нутгийн зураглал, сургууль, цэцэрлэг, нийгмийн үйлчилгээний байгууллага, нийтийн тээврийн үйлчилгээний хуваарь, байгаль орчин, цаг агаарын онцлог гэх мэт);

13.4.2.шинэ орчинд дасан зохицох үеийн сэтгэл зүйн хямрал, санаа зовинолыг даван туулахад туслах аргуудын талаарх сургалт;

13.4.3.шинэ орчинд шаардлагатай ур чадвар олгох сургалт (хот болон хөдөөгийн соёлын ялгаа, онцлог, хэл, амьдралын хэв маяг, технологийн хэрэгсэл ашиглах гэх мэт).

13.4.Шилжин суурьшсан өрх, иргэнийг **хөдөлмөр эрхлэлтийг дэмжих** үйлчилгээнд холбон зуучлах: ажилд ороход шаардлагатай хувь хүний ур чадварыг дэмжсэн сургалтад хамруулах, ажил хайх, тогтвортой хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, ажлын байранд зуучлах, мэргэжлийн байгууллагад холбон зуучилна.

13.5.Шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай **өрхийн хүүхдийг өдрийн үйлчилгээнд хамруулах**: хүүхдийг сурч хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор тохь, тухтай дулаан орчинд гэрийн даалгавараа хийх, хичээлийн хоцрогдол арилгах, уншлагын дугуйлан, харилцааны ур чадвар, багаар ажиллах, илтгэл тавих гэх мэт өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, хувийн ариун цэвэр сахих, цаг төлөвлөлт, гар урлал, урлаг, дуу хөгжим, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, дасгал хөдөлгөөнийг нэмэгдүүлэх сургалтуудад хамруулна.

Арван дөрөв. Эдгэшгүй хүнд өвчтэй иргэнд үзүүлэх үйлчилгээ заавар

14.1.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь эдгэшгүй хүнд өвчтэй иргэнд дараах хэлбэрээр үйлчилгээ үзүүлнэ:

14.1.1 зөвлөгөө өгөх;

14.1.2.гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ.

14.2.Эдгэшгүй хүнд өвчтэй иргэний сэтгэл санааг дэмжих, өвчнөө даван туулахад нь туслах зорилгоор сэтгэл зүйн зөвлөгөө, эрүүл мэндийн зөвлөгөө болон өв залгамжлал, гэрээслэл зэрэг хууль зүйн зөвлөгөө үзүүлнэ.

14.3.Эдгэшгүй хүнд өвчтэй иргэнд гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг энэ журмын 6.8-д заасны дагуу, асарч буй иргэнд болон гэр бүлийн гишүүнд энэ журмын 6.7.5-д заасан үйлчилгээг тус тус үзүүлнэ.

Арван тав. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хөдөлмөр эрхлэлт, орлогын эх үүсвэрийг дэмжих үйлчилгээ үзүүлэх заавар

15.1.Сум, хорооны нийгмийн ажилтан нь Амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан

бөгөөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдаж байгаа өрх, иргэнээс ил тод байдлаар сонгон нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох, төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлнэ.

15.2.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь энэ журмын 4.1.12-т заасан үйлчилгээг дараах байдлаар үзүүлнэ:

15.2.1.тухайн өрхийн гишүүдийн нөөц, бололцоо, хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхол зэргийг өрхийн гишүүдтэй хамтран тодорхойлж, нөхцөл байдлын үнэлгээ хийх;

15.2.2.тухайн өрхийн гишүүдтэй хамтран өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах;

15.2.3.тухайн өрхийн хүүхдийг сургууль, цэцэрлэгт бүрэн хамруулах, хүүхдийг хоол тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчинд өсгөх, эерэг хүмүүжлийн аргууд, хүүхдийн боловсрол, нас сэтгэл зүйн онцлогийн талаар сургалтад хамруулах;

15.2.4.өрхийн гишүүдийн сэтгэл зүйн сайн сайхан байдлаа нэмэгдүүлэх, өөрийн давуу талыг илрүүлэх, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд туслах (өөрийн нөөц бололцоог танин мэдэх, харилцааны ур чадвар, зан хандлагаа өөрчлөх, багаар ажиллах, эрүүл аж төрөхтэй холбоотой гэх мэт) сургалт, зөвлөгөө, дэмжих бүлэгт хамруулах;

15.2.5.дэмжин туслах ажилтан өрхийн гишүүдтэй тогтмол харилцаж, тэдний асуудлыг сонсож шийдвэрлэхэд туслах, хамтын хүчээр асуудлыг шийдвэрлэх зорилгоор хамтран ажиллах бүлэг байгуулах;

15.2.6.өрхийн гишүүдэд санхүүгийн боловсрол олгох, хадгаламж үүсгэх, зээл ашиглах, орлогоо зөв зарцуулах талаар сургалт явуулж, хамтын хуримтлал үүсгэхэд туслах;

15.2.7.өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор мал аж ахуй, газар тариалан, бичил бизнес зэрэг орон нутгийн онцлогт тохирсон аж ахуй эрхлэх, хамтран төсөл боловсруулах сургалт зохион байгуулах;

15.2.8.ажилд ороход шаардлагатай мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний ур чадварыг дэмжсэн сургалтад хамруулах, мэргэжил, сургалтын байгууллагад холбон зуучлах, ажил хайх, ажлын байранд зуучлах зэргээр аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад холбон зуучлах;

15.2.9.тухайн өрхийн гишүүдийн ур чадвар, нөөц бололцоонд түшиглэн, орлогын эх үүсвэртэй болгох зорилгоор төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног, төхөөрөмж, түүхий эд, материал худалдан авч өгөх, зөвлөн туслах;

15.2.10.төслийн хэрэгжилтийн явцад өрхийн орлогын өсөлт, хоол хүнс, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг хагас жил тутам үнэлж, урт хугацаанд бие даан амьдрах бололцоотой болсон эсэхийг үнэлэх;

15.2.11.иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын нийгмийн ажилтан нь сум, хорооны нийгмийн ажилтантай хамтран тухайн өрх тогтвортой

орлогын эх үүсвэртэй болсон, хадгаламжтай болсон, цаашид өөрийгөө болон гэр бүлээ тэжээн тэтгэх чадвартай болсон эсэхэд үнэлгээ хийж, хөтөлбөрөөс гаргах.

15.3.Тухайн өрхийн нөхцөл байдлаас шалтгаалан нэг өрхөд зарцуулах үйлчилгээний хугацаа 3 хүртэл жил байна.

Арван зургаа. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зохион байгуулалт

16.1.Энэ журмаар Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан өрх, иргэнд тус хуулийн 18.1-т заасан үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

16.2.Үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулахдаа Нийгмийн халамжийн тухай хуулийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан өрх, иргэнд тус хуулийн 18.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, энэхүү журам болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

16.3.Үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай, шударга өрсөлдөөнтэй байх зарчмыг баримтална.

16.4.Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан өрх, иргэний онцлог хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн, тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасан үйлчилгээг дараах хэлбэрээр багцлан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар үзүүлнэ:

16.4.1.энэ журмын 6.2-6.4-т заасан хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц үйлчилгээ;

16.4.2.энэ журмын 6.5-д заасан хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц үйлчилгээ;

16.4.3.энэ журмын 7.1.1-7.1.4-т заасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхөд үзүүлэх цогц үйлчилгээ;

16.4.4.энэ журмын 7.1.5-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхөд үзүүлэх цогц үйлчилгээ;

16.4.5.ахмад настны цогц тусламж, үйлчилгээ;

16.4.6.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх цогц үйлчилгээ;

16.4.7.хүчирхийлэлд өртсөн иргэнд үзүүлэх цогц үйлчилгээ;

16.4.8.согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэнд үзүүлэх үйлчилгээ

16.4.9.хорих ангиас суллагдсан иргэнд үзүүлэх үйлчилгээ;

16.4.10.гэр оронгүй, оршин суух тодорхой хаяггүй иргэнд үзүүлэх үйлчилгээ;

16.4.11.өрх толгойлсон эх, эцэг, тухайн өрхийн хүүхдэд чиглэсэн үйлчилгээ;

16.4.12.шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх үйлчилгээ;

16.4.13.эдгэшгүй хүнд өвчтэй иргэнд үзүүлэх үйлчилгээ;

16.4.14.нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хөдөлмөр эрхлэлт, орлогын эх үүсвэрийг дэмжих үйлчилгээ.

16.5.Энэхүү журмаар Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан өрх, иргэнд тус хуулийн 18.1-т заасан заасны дагуу аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулахдаа тухайн жилийн үйлчилгээний батлагдсан төсөвт өртөгт багтаан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнд нийцүүлэн гарсан холбогдох журмын дагуу зохион байгуулна.

16.6.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.” гэснийг баримтална.

16.7.Энэ журмын 16.4.1-16.4.14-т заасан үйлчилгээний нийт батлагдсан төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.

16.8.Энэ журмын 16.4.1-16.4.14-т заасан үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан үйлчилгээний жишиг үнэ, тарифыг баримтлан үзүүлнэ.

16.9.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд энэ журмын 16.4.1-16.4.14-т заасан үйлчилгээний багцыг тухайн орон нутагт хөгжлийн ордон, болон бусад хэлбэрээр эсэх, газар нутгийн байршил, үйлчлүүлэгчдийн тоо, зэргээс хамааран аймагт сумаар, дүүрэгт хороогоор багцлан тусгана.

Арван долоо. Үйлчилгээний чанарт тавигдах шалгуур

17.1.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь энэ журмын 16.4.1, 16.4.3, 16.4.8, 16.4.9, 16.4.11, 16.4.12, 16.4.13, 16.4.14–т заасан үйлчилгээг үзүүлэхдээ дараах чанарт тавигдах шалгуурыг хангасан байна:

17.1.1.байгууллага нь өөрийн өмчийн эсвэл түрээсийн байртай байх, аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан тохилог орчин, хүртээмжтэй дэд бүтэцтэй, интернэт, харилцаа холбоотой байх, байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарийг ил тод байршуулсан байх, хөгжлийн төвийн үйлчилгээ үзүүлэх анги танхим, техник, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнтэй байх, яаралтай үед хэрэглэх эмнэлгийн анхны тусламж үзүүлэх хэрэгсэлтэй байх.

17.1.2.үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн нийгмийн ажилтан, үйл ажиллагааны менежерийг орон тоогоор, багш, сэтгэл зүйч, эмч, хуульч, сувилагч, үйлчилгээний ажилтанг гэрээгээр, боловсон хүчин мэргэжлийн дипломтой байх, ажилтны ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолттой байх, сургалт, үйлчилгээний хөтөлбөр, төлөвлөгөөг 7 хоногоор, сар, жилээр гаргах, үйлчилгээ үзүүлэх заавар /дотоод журам/-тай байх, архи, мансууруулах донтой, сэтгэцийн,

сүрьеэ халдварт өвчтэй хүн ажиллуулахгүй байх, сүүлийн гурван жилийн үйл ажиллагааны тайлантай байх;

17.2. Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь энэ журмын 16.4.2, 16.4.4, 16.4.7, 16.4.10-т заасан үйлчилгээг үзүүлэхдээ энэ журмын 17.1.1, 17.1.2-т заасан чанарын шалгуур үзүүлэлтээс гадна дараах нэмэлт шаардлагуудыг давхар хангана:

17.2.1.энэ журмын 16.4.2, 16.4.4-т заасан үйлчилгээг үзүүлж буй байгууллага нь эмч, сувилагч, туслах ажилтанг орон тоогоор ажиллуулах ба гэрээр үйлчилгээ үзүүлэх тээврийн хэрэгсэлтэй байх

17.2.2.энэ журмын 16.4.7-д заасан үйлчилгээ үйлчилгээг үзүүлж буй байгууллага нь Хохирогч түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS6040:2019 Монгол Улсын стандартыг хангасан байх

17.2.3.энэ журмын 16.4.10-т заасан үйлчилгээ үзүүлж буй байгууллага нь гал тогоо, хоолны өрөө, угаалгын өрөө, зориулалтын бие засах газар, халуун усанд орох шүршүүр, унтах ор, хөнжил, улиралд тохирсон солих хувцах, эрүүл аюулгүй хоол хүнсээр хангах, төвийн цахилгаанд холбогдсон, хувийн дэд бүтэц цэвэр усны худаг, усны шинжилгээ, бохирын хувийн дэд бүтэцтэй байх.

17.2.4.иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь тухайн чиглэлээр өмнө нь төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байсан, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл гаргаж, шүүхээр тогтоож байгаагүй бол давуу тал болох.

Арван найм. Хяналт, үнэлгээ

18.1.Үйлчилгээг дараах агуулгын хүрээнд аймаг, дүүрэг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын хяналтын нэгж, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагыг хяналтын нэгж, ажилтан, улсын байцаагч тус тусын чиг үүргийн хүрээнд хяналт, үнэлгээ хийнэ:

18.1.1.уялдаа холбоо, зорилгод нийцэж буй байдал;

18.1.2.үр дүнтэй хэрэгжүүлсэн байдал;

18.1.3.үр ашигтай хэрэгжүүлсэн байдал;

18.1.4.хувь хүн, орон нутаг, нийгэмд үзүүлсэн үр нөлөө;

18.1.5.тогтвортой үргэлжлэх чадамж.

18.2.Үйлчилгээний **уялдаа холбоо, зорилгод нийцэж буй байдлыг** хэмжих шалгуур үзүүлэлтүүд:

18.2.1.үйлчилгээг Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.2 дахь хэсэгт заасан өрх, иргэнд үзүүлж буй эсэх;

18.2.2.иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэл нь үзүүлж буй үйлчилгээтэй нийцэж буй эсэх;

18.2.3.үзүүлж буй үйлчилгээ анх тавьсан зорилго, ирүүлсэн төлөвлөгөө болон нийгмийн ажилтны кэйс төлөвлөгөөтэй уялдаж буй эсэх;

18.2.4.үйлчлүүлэгчийн хэрэгцээ, шаардлагыг хангаж чадсан эсэх.

18.3.Үр дүнтэй хэрэгжүүлсэн байдлыг хэмжих шалгуур үзүүлэлтүүд:

18.3.1.үйлчилгээнд хамрагдсан өрх, иргэний тоо, үүнээс нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг хамруулсан хувь;

18.3.2.үзүүлсэн үйлчилгээний төрөл, тоо, давтамж (үйлчлүүлэгч тус бүрээр);

18.3.3.боловсруулсан сургалтын материал, гарын авлага, тараах материалын тоо;

18.3.4.боловсруулсан кэйс төлөвлөгөө, уулзалтын тэмдэглэл хөтөлсөн бүртгэл, тоо (үйлчлүүлэгч тус бүрээр);

18.3.5.хамтран ажиллаж, үйлчлүүлэгчийг холбон зуучилсан байгууллагын тоо;

18.3.6.үйлчлүүлэгчээс ирсэн гомдол санал, хүсэлтийн тоо, шийдвэрлэсэн хувь;

18.3.7.үйлчилгээний сэтгэл ханамжийн хувь;

18.3.8.үйлчлүүлэгчтэй харилцсан ёс зүй, хандлагын үнэлгээ.

18.4.Үр ашигтай хэрэгжүүлсэн байдлыг хэмжих шалгуур үзүүлэлтүүд:

18.4.1.үйлчилгээг төлөвлөгөөт цаг хугацаанд хэрэгжүүлсэн эсэх;

18.4.2.үйлчилгээг анх төсөвлөсөн төсөвт багтаан, үр ашигтайгаар хэрэгжүүлсэн эсэх;

18.4.3.үйлчилгээнд шаардлагатай хүний нөөцийг зөв хуваарилан, удирдлагаар хангаж ажилласан эсэх;

18.4.3.нэг үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлсэн хугацаа, үйлчилгээнд зарцуулсан нийт зардал.

18.5. Хувь хүн, орон нутаг, нийгэмд үзүүлсэн үр нөлөөг хэмжих шалгуур үзүүлэлтүүд:

18.5.1.үйлчилгээ авсан өрх, иргэний мэдлэг, зан хандлага, дадал, амьдралын чанарт гарсан өөрчлөлт (чанарын судалгаа, ярилцлага);

18.5.2.ажилд зуучилсан, ажилд шинээр орж өрх, иргэний тоо;

18.5.3.өрхийн орлогоо нэмэгдүүлж тогтвортой орлоготой болсон өрх, иргэний тоо;

18.5.4.тогтвортой гэр оронтой болсон өрх, иргэний тоо;

18.5.5.сургууль завсардсан байсан хүүхэд сургуульд хамрагдсан хувь;

18.5.6.согтуурах, мансуурах донтой өвчтэй иргэний донтолтоос гарсан хувь.

18.5.7.бичиг, баримттай болсон өрх, иргэний тоо.

18.5.8.хуримтлалтай болсон өрх, иргэний тоо.

18.6.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын үйлчилгээний тогтвортой үргэлжлэх чадамжийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд:

18.6.1.үйлчилгээ үзүүлж буй орон нутагт байршил, харъяалалтай эсэх;

18.6.2.үйлчилгээ үзүүлж буй байр тогтмол эсэх;

18.6.3.орон тооны хүний нөөцийн тоо;

18.6.4.байгууллагын дотоод дүрэм, журам, бодлогын тоо; (ажлын байрны ёс зүй, хүүхэд хамгааллын бодлого, бэлгийн дарамт хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бодлого гэх мэт);

18.6.5.үйлчилгээ үзүүлсэн мэргэжилтэн мэргэжлийн диплом, гэрчилгээтэй эсэх;

18.6.6.үйлчилгээ үзүүлсэн ажилтнуудын мэргэжлийн сургалтад хамрагдсан байдал;

18.6.7.үйлчилгээний явцад гарсан, алдаа зөрчлийн тоо;

18.6.8.хувийн мэдээллийг нууцлан үйлчлүүлэгчийн гомдол, саналыг хүлээн авах саналын хайрцаг зэрэг бусад суваг ашиглаж байгаа эсэх;

18.6.9.орон нутгийн өрх, иргэдэд танигдсан байдал.

18.7.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь үйлчилгээнд хамрагдсан иргэнийг үнэн зөв тогтоосон эсэх, үйлчилгээ нь төлөвлөгөөний дагуу, үр дүнтэй, чанартай хэрэгжиж буй эсэхэд хийх хөндлөнгийн болон олон нийтийн хяналт, шалгалтыг энэ журмын 18.1.1-18.1.5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үйлчилгээ хүлээн авсан иргэн, даван туулагч, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын төлөөлөл, орон нутгийн иргэний төлөөлөл оролцуулсан үнэлгээний ажлын хэсэг гарган хагас, бүтэн жилээр зохион байгуулна.

18.8.Үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг цаасан болон цахим /киоск, мессеж/ хэлбэрээр ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг үнэлж, сэтгэл ханамжийн судалгааны дүнд үндэслэн үйлчилгээг сайжруулах, сургалт зохион байгуулах арга хэмжээг зохион байгуулна.

Арван ес. Бусад

19.2.Хуурамчаар баримт бичиг үйлдсэн өрх, иргэн, хуулийн этгээд, түүнчлэн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэнийг буруу тогтоосон, тодорхойлолтыг үндэслэлгүйгээр буюу хуурамчаар үйлдсэн, нийгмийн үйлчилгээний сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан албан тушаалтанд Нийгмийн халамжийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэж, үзүүлсэн үйлчилгээний зардлыг хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлнэ.

19.3.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагаас үйлчилгээнд хамрагдсан өрх, иргэдийн талаарх холбогдох мэдээ, тайланг гаргуулан авч нэгтгэн нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хагас жил болон жилийн эцэст хүргүүлнэ.

19.4.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь иргэдийн санал, гомдлыг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авах, тусгай дугаар бүхий нээлттэй утас ажиллуулах, цахим хаяг тогтмол ажиллуулах зэргээр иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч тухай бүр шийдвэрлэнэ.

19.5.Энэ журмын 4.1.1-4.1.12-т заасан үйлчилгээ үзүүлэх ажилтнуудад сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага улирал тутам тогтмол зохион байгуулна.

19.6.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан энэ журмын 4.1.1-4.1.12-т заасан үйлчилгээний тендер шалгаруулалтын зарлалыг tender.gov.mn цахим системээс гадна улс, орон нутгийн хэвлэл, телевиз, нийгмийн сүлжээ зэрэг мэдээллийн хэрэгсэл, цахим хуудас, байгууллагын самбар зэрэгт байрлуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад сургалт, сурталчилгаа хийж сонгон шалгаруулалтын ил тод байдлыг ханган ажиллана.

19.7.Сонгон шалгаруулалттай холбоотой гомдол, маргааныг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хууль болон холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.

19.8.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол буруутай албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн 48.1, хөдөлмөрийн гэрээтэй ажилтанд Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2-т заасан сахилгын шийтгэлийг зөрчлийн шинж байдалд тохируулан ногдуулна.

----oOo---

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны дүгээр сарын-ны өдрийн..... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ (ЖИШИГ ЗАГВАР)

20... он.....сар.....өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага / Газар, хэлтэс (цаашид захиалагч тал гэх), нөгөө талаас Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллага, аж ахуй нэгж (цаашид гүйцэтгэгч тал гэх) нар “Нийгмийн халамжийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2, 18.1.3, 18.1.4, 18.1.5, 18.1.6, 18.1.8 дахь хэсэгт заасан үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын үр дүнд гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх харилцааг зохицуулахаар байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээг Нийгмийн халамжийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, хуульд заасан эрх бүхий байгууллагаас баталсан **Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ** үзүүлэх журам, аргачлал, шалгууртай нийцүүлэн нэг талаас Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага / Газар, хэлтэс/ нөгөө талаас **Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх** төрийн бус байгууллага, аж ахуй нэгж нар хамтран **олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн.....үйлчилгээг** үзүүлэх зорилгоор дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2.Талууд “Нийгмийн халамжийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 – 18.1.6, 18.1.8 дахь хэсэгт заасан үйлчилгээг 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зорилтот бүлгийн иргэдэд үзүүлнэ.

1.3.Захиалагч болон гүйцэтгэгч тал нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар баталсан “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал”-д заасан үнэ, тариф, хугацааг гэрээнд тусгаж өгнө.

1.4.Гэрээ байгуулаагүй тохиолдолд гүйцэтгэгч талд аливаа санхүүжилт хийгдэхгүй.

1.5.Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Нийгмийн халамжийн тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан Засгийн газрын тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан журам, шалгуураар зохицуулна.

1.6.Энэхүү гэрээг 202... оны сарын өдрөөс оны сарын өдөр хүртэл жил/сар хугацаатай байгуулав.

1.7.Энэхүү гэрээг 2 хувь үйлдсэн бөгөөд баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

1.8.Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй, нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Хоёр. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг

2.1.Үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийн дэлгэрэнгүй судалгааг Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, /хэлтэс/-ээс гаргуулан авч мэдээллийн сан бүрдүүлэх / Иргэний овог, нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, үйлчилгээ авсан хугацаа, эхлэх, дуусах он, сар, өдөр /

2.2.Үйлчилгээнд хамрагдаж буй өрх, иргэн тус бүрд хувийн хэрэг нээж, үйл явцын тэмдэглэлийг он сар, өдрөөр хөтлөх, нөхцөл байдал, гарсан өөрчлөлт, үр дүнгийн үнэлгээ хийх;

2.3.Үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг сар, улирлаар гарган Аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, /хэлтэс/-ээр батлуулан хэрэгжүүлэх;

2.4.Үйлчилгээнд хамрагдаж буй өрх, иргэдэд тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх ;

2.5.“Нийгмийн халамжийн тухай” хууль болон холбогдох дүрэм, журам, стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх;

2.6.Холбогдох газруудаас зохион байгуулж буй сургалт, семинар, уулзалтад тогтмол оролцож, гарсан шийдвэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх;

2.7.Үйлчилгээтэй холбоотой гарсан зардал санхүүгийн баримт материалыг баримтжуулан бүрдүүлэх;

2.8.Гүйцэтгэгч нь гэрээгээр үзүүлсэн үйлчилгээтэй холбогдон зарцуулсан хөрөнгийн нэхэмжлэлийг холбогдох баримтын хамт бүрдүүлэн захиалагчийн шаардсан хугацаанд хүргүүлэх;

2.9.Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, байршил, шуудангийн хаяг, харилцах утас өөрчлөгдсөн тохиолдолд өөрчлөлтийг тухай бүр мэдээлэх;

2.10.Гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, хугацаандаа ирүүлээгүй, тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болох бөгөөд дараа жил гэрээ байгуулахаас татгалзах үндэслэл болно.

2.11.Үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам гаргаж, хэрхэн шийдвэрлэсэн тухай тэмдэглэл хөтлөн хадгалах; Хэрэгжүүлэх Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар үйлчилгээний хүрээнд иргэдээс гарсан санал, өөрсдийн судалгаанд тулгуурлан үйлчилгээний талаарх санал, санаачилгыг холбогдох байгууллагуудад албан ёсоор хүргүүлж танилцуулах;

2.12.Үйлчлүүлэгчийн нэр дээр өөр хүн үйлчлүүлсэн нь холбогдох байгууллагуудын шалгалтаар илэрсэн тохиолдолд түүнээс үүссэн зардлыг тухайн байгууллага өөрөө хариуцах бөгөөд энэ нь гэрээ цуцлах үндэслэл болно.

2.13.Иргэн ижил төрлийн үйлчилгээг давхардаж авсан тохиолдолд үйлчилгээний зардлыг олгохгүй бөгөөд аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, /хэлтэс/ хариуцахгүй.

2.14.Иргэд, үйлчлүүлэгчдээс харилцааны, ёс зүйн асуудлын талаар ямар нэг гомдол гаргахгүй байх;

2.15.Хамтран ажиллах хугацаанд үйлчилгээний хэрэгжилтийн талаарх санал дүгнэлтийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

Гурав. Захиалагчийн хүлээх эрх, үүрэг

3.1. Сум, хорооны нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн “e-halamj” системээс татагдахгүй, үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй өрх, иргэдийн бичиг баримтыг бүрдүүлэн “Амьжиргааг дэмжих зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж хамрагдах иргэдийн нэрсийг гүйцэтгэгчид гаргаж өгөх;

3.2. Гүйцэтгэгчид “Нийгмийн халамжийн тухай” хууль бусад хууль тогтоомжууд тэдгээрийг хэрэгжүүлэх дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангах талаар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;

3.3. “Нийгмийн халамжийн тухай” хууль болон холбогдох хууль тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан эрх зүйн актуудад гарч буй өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүр өгөх;

3.4. Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний чиглэлээр холбогдох сургалт, семинар, уулзалтад гүйцэтгэгчийг хамруулах;

3.5. Гүйцэтгэгчийн гэрээгээр гүйцэтгэж буй үйлчилгээнд олгох санхүүжилтийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас баталсан олголтын хуваарийн дагуу гүйцэтгэлээр нь.....банкин дахь.....тоот харилцах дансанд нь шилжүүлэх;

3.6. Гүйцэтгэгчийн үйлчилгээтэй холбоотой гаргасан санал хүсэлтийг хамтран шийдвэрлэх;

3.7. Олгосон санхүүжилт, түүний ажлын явц, үр дүн, гүйцэтгэлтэй тухай бүр танилцаж үйл ажиллагаанд нь хяналт тавих;

3.8. Гэрээний биелэлтэд хийх үнэлгээг хагас жил тутамд явуулах;

3.9. Гүйцэтгэгч талтай улирал, жилийн эцсээр гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын тооцоог хийж, тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулан авах;

3.10. Иргэдээс гаргасан санал, хүсэлтийн дагуу үйлчилгээний талаар ажлын чиглэл, санал боловсруулан гүйцэтгэгчид хүргүүлэх;

3.11. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын сунгах, цуцлах саналыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх.

Дөрөв. Төлбөрийн нөхцөл

4.1. Гэрээний төлбөрийг жил бүр гэрээнд заасан журмын дагуу захиалагч санхүүжүүлнэ.

4.2. Гэрээний эхний жилд талууд гэрээ байгуулж, гүйцэтгэгчээс тухайн жилийн гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг захиалагчид ирүүлснээр тухайн жилийн гүйцэтгэх ажлын төсвийн 20 хувийг гүйцэтгэгчид олгоно, хагас жилийн тайланг үндэслэн тухайн жилийн төсвийн 30 хувийг, жилийн эцсийн тайлан, гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн үлдсэн 50 хувийг тус тус олгоно.

4.3. Гэрээ байгуулсан хоёр дахь жилээс гүйцэтгэгч талаас тухайн жилийн төлөвлөгөөг ирүүлсний дараа гэрээний 4.2-т заасан журмын дагуу санхүүжилтийг хуваарийн дагуу олгоно.

4.4. Гэрээний сүүлийн жил, жилийн эцсийн санхүүжилтийг олгохдоо гэрээг бүхэлд нь дүгнэж санхүүжилтийг олгоно.

Тав. Бусад

4.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, баталснаар хүчин төгөлдөр болох бөгөөд энэ өдрөөс эхлэн гэрээгээр хүлээсэн тус тусын үүргээ хэрэгжүүлнэ.

4.2. Уг гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах болон гэрээг бүхэлд нь буюу хэсэгчлэн цуцлах асуудлыг хоёр тал харилцан шийдвэрлэнэ.

4.3.Аль нэг тал нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь гэрээг цуцлах санал тавих эрхтэй.

4.4.Гэрээний талаар гарсан маргаантай асуудлыг харилцан шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

4.5.Талууд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн үүргийг биелүүлж ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээнэ.

Гэрээ байгуулсан талууд:

Гэрээг байгуулсан:

Гэрээг байгуулсан:

“_____ Аймаг, дүүргийн Хөдөлмөр,

халамжийн үйлчилгээний газар, хэлтсийг төлөөлж
төлөөлж:

“_____”-ийг

Албан тушаал _____
тушаал _____

Албан

Нэр _____ /

/

Нэр _____ /

/

/Гарын үсэг/

/Гарын үсэг/

Харилцах утас:

Харилцах утас: